



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Шинэ-идэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/179/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Хөвсгөл аймаг
2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ
Утас: 99900662 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn
Ахлах аудитор: Л.Мандахнаран
Утас: 92118277 Цахим хаяг: MandakhnaranL@audit.gov.mn
Ньюбаланс аудит ХХК-ийн Захирал: Б.Лхагвадорж
Утас: 99101901 Цахим хаяг:
Newbalance.lhagvaa@gmail.com
Аудитор: Ё.Байгалмаа
Утас: 99025579 Цахим хаяг: yobaigal5579@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.25 № 01/218
танай _____ -ны № _____ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ШИНЭ-ИДЭР
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Р.АМАРБАЯСГАЛАН ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
			/Төгрөгөөр/
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>61,130,770.00</u>	<u>68,888,740.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	61,130,770.00	68,888,740.00
351	Түүхий эд материал	1,449,700.00	379,000.00
35130	Эм боох материал	1,449,700.00	379,000.00
354	Хангамжийн материал	59,681,070.00	68,509,740.00
35410	Бичиг хэргийн материал	180,000.00	57,500.00
35460	Хүнсний материал	12,061,330.00	8,706,650.00
35470	Бусад хангамжийн материал	47,439,740.00	59,745,590.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,356,173,029.98</u>	<u>2,326,907,335.68</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,356,173,029.98	2,326,907,335.68
392	Биет хөрөнгө	2,349,010,029.90	2,319,799,335.56
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,494,963,466.79	2,493,552,216.79
39202	Хуримтлагдсан элэгдэл	-175,163,455.92	-221,237,557.72
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	32,764,910.00	30,792,553.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-18,879,533.32	-8,377,008.30
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,417,964.00	17,042,554.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6,437,431.25	-7,544,054.82
39214	Бусад үндсэн хөрөнгө	17,398,035.00	20,373,468.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-12,398,035.40	-8,146,945.89
39217	Ном	3,344,110.00	3,344,110.00
393	Биет бус хөрөнгө	7,163,000.08	7,108,000.12
39301	Програм хангамж	275,000.00	275,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-109,999.92	-164,999.88
39303	Бусад биет бус хөрөнгө	6,998,000.00	6,998,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,417,303,799.98</u>	<u>2,395,796,075.68</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,417,303,799.98</u>	<u>2,395,796,075.68</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,417,303,799.98	2,395,796,075.68
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	108,675,623.00	108,675,623.00
51101	Өмч: - төрийн	108,675,623.00	108,675,623.00
512	Хуримтлагдсан үр дүн	2,231,065,244.85	2,210,697,220.55
51210	Өмнөх үеийн үр дүн	2,231,065,244.85	2,232,204,944.85
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-21,507,724.30
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	77,562,932.13	76,423,232.13
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,417,303,799.98</u>	<u>2,395,796,075.68</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	380,235,615.00	378,884,935.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,708,315.00	26,686,869.50
120	Нийтлэг татварын бус орлого	7,708,315.00	26,686,869.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,708,315.00	26,686,869.50
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,708,315.00	26,686,869.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	52,187,300.00	56,488,966.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	320,340,000.00	295,709,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	778,166.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	778,166.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	52,187,300.00	55,710,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	52,187,300.00	55,710,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	385,233,338.50	400,392,659.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	385,233,338.50	400,392,659.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	365,605,724.50	386,767,521.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	211,817,007.00	226,060,330.00
210101	Үндсэн цалин	211,817,007.00	226,060,330.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,341,862.00	29,710,919.00
210201	Тэтгэврийн даатгал	17,869,186.00	20,503,419.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,118,170.00	2,301,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,694,534.00	1,841,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	423,633.00	460,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,236,339.00	4,603,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,274,688.00	50,328,263.00
210301	Гэрэл, цахилгаан	1,606,831.00	1,449,181.00
210302	Түлш, халаалт	45,699,382.00	48,719,082.00
210303	Цэвэр, бохир ус	968,475.00	160,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,247,959.00	5,612,516.00
210401	Бичиг хэрэг	191,500.00	345,100.00
210402	Тээвэр, шатахуун	1,436,259.00	1,850,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	230,000.00	150,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	616,600.00	778,166.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,773,600.00	2,489,250.00
2105	Нормативт зардал	17,913,810.00	12,159,330.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,308,600.00	1,144,900.00

210502	Хоол, хүнс	16,605,210.00	11,014,430.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,272,700.00	2,272,700.00
210604	Урсгал засвар	2,272,700.00	2,272,700.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	56,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	56,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	315,500.00	836,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,500.00	296,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	540,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,422,198.50	59,730,563.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	320,000.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,529,700.00	4,714,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	51,572,498.50	55,016,063.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,627,614.00	13,625,138.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	817,500.00	100,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	817,500.00	100,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	17,170,202.00	10,415,301.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,170,202.00	10,415,301.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,639,912.00	3,109,837.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,639,912.00	3,109,837.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-4,997,723.50	-21,507,724.30
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-4,997,723.50	-21,507,724.30

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	108,675,623.00	77,562,932.13	2,231,065,244.85	2,417,303,799.98
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	108,675,623.00	77,562,932.13	2,231,065,244.85	2,417,303,799.98
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,139,700.00	1,139,700.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	108,675,623.00	77,562,932.13	2,232,204,944.85	2,418,443,499.98
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-1,139,700.00	00.00	-1,139,700.00

D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-21,507,724.30	-21,507,724.30
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	108,675,623.00	76,423,232.13	2,210,697,220.55	2,395,796,075.68

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	372,527,300.00	352,198,066.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	372,527,300.00	352,198,066.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	320,340,000.00	295,709,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	778,166.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	778,166.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	52,187,300.00	55,710,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	52,187,300.00	55,710,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	365,412,300.00	349,698,066.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	365,412,300.00	349,698,066.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	345,784,686.00	336,072,928.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	211,817,003.00	226,060,330.00
210101	Үндсэн цалин	175,234,847.00	154,690,633.00
210102	Нэмэгдэл	21,746,756.00	54,339,900.00
210104	Урамшуулал	14,835,400.00	17,029,797.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,341,866.00	29,710,919.00
210201	Тэтгэврийн даатгал	18,218,957.00	20,503,419.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,030,800.00	2,301,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,624,600.00	1,841,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	406,100.00	460,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,061,409.00	4,603,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,274,688.00	50,328,263.00
210301	Гэрэл, цахилгаан	1,606,831.00	1,449,181.00
210302	Түлш, халаалт	45,699,382.00	48,719,082.00
210303	Цэвэр, бохир ус	968,475.00	160,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,041,759.00	4,188,166.00
210401	Бичиг хэрэг	371,500.00	222,600.00
210402	Тээвэр, шатахуун	1,436,259.00	1,850,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	230,000.00	150,000.00
210404	Ном, хэвлэл	5,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,317,600.00	778,166.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,681,400.00	1,187,400.00
2105	Нормативт зардал	37,802,870.00	8,476,050.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,758,300.00	74,200.00
210502	Хоол, хүнс	24,712,370.00	7,659,750.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,332,200.00	742,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,372,700.00	10,272,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	100,000.00	00.00
210602	Тавилга	00.00	8,000,000.00
210604	Урсгал засвар	2,272,700.00	2,272,700.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	56,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	56,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	315,500.00	836,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,500.00	296,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	540,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,818,300.00	6,143,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	320,000.00	175,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,498,300.00	5,968,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,627,614.00	13,625,138.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	817,500.00	100,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	817,500.00	100,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	17,170,202.00	10,415,301.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,170,202.00	10,415,301.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,639,912.00	3,109,837.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,639,912.00	3,109,837.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>7,115,000.00</u>	<u>2,500,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>7,115,000.00</u>	<u>2,500,000.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>7,115,000.00</u>	<u>2,500,000.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	<u>7,115,000.00</u>	<u>2,500,000.00</u>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,115,000.00	2,500,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-7,115,000.00</u>	<u>-2,500,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	351,419,900.00	337,894,762.00	13,525,138.00	96.2%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	351,419,900.00	337,894,762.00	13,525,138.00	96.2%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	351,319,900.00	337,794,762.00	13,525,138.00	96.2%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	230,184,300.00	226,060,330.00	4,123,970.00	98.2%
210101	Үндсэн цалин	158,709,000.00	154,690,633.00	4,018,367.00	97.5%
210102	Нэмэгдэл	54,339,900.00	54,339,900.00	00.00	100.0%
210104	Урамшуулал	17,135,400.00	17,029,797.00	105,603.00	99.4%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,075,000.00	29,710,919.00	1,364,081.00	95.6%
210201	Тэтгэврийн даатгал	21,867,500.00	20,503,419.00	1,364,081.00	93.8%
210202	Тэтгэмжийн даатгал	2,301,900.00	2,301,900.00	00.00	100.0%
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,841,500.00	1,841,500.00	00.00	100.0%
210204	Ажилгүйдлийн даатгал	460,400.00	460,400.00	00.00	100.0%
210205	Эрүүл мэндийн даатгал	4,603,700.00	4,603,700.00	00.00	100.0%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,438,100.00	50,328,263.00	3,109,837.00	94.2%
210301	Гэрэл, цахилгаан	3,919,000.00	1,449,181.00	2,469,819.00	37.0%
210302	Түлш, халаалт	48,719,100.00	48,719,082.00	18.00	100.0%
210303	Цэвэр, бохир ус	800,000.00	160,000.00	640,000.00	20.0%
2104	Хангамж, бараа материалын зардал	3,668,100.00	3,410,000.00	258,100.00	93.0%
210401	Бичиг хэрэг	222,600.00	222,600.00	00.00	100.0%
210402	Тээвэр, шатахуун	1,850,000.00	1,850,000.00	00.00	100.0%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	222,600.00	150,000.00	72,600.00	67.4%
210404	Ном, хэвлэл	185,500.00	00.00	185,500.00	0.0%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,187,400.00	1,187,400.00	00.00	100.0%
2105	Нормативт зардал	12,634,100.00	8,476,050.00	4,158,050.00	67.1%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	74,200.00	74,200.00	00.00	100.0%
210502	Хоол, хүнс	11,817,800.00	7,659,750.00	4,158,050.00	64.8%

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	742,100.00	742,100.00	00.00	100.0%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,772,700.00	12,772,700.00	00.00	100.0%
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,500,000.00	2,500,000.00	00.00	100.0%
210602	Тавилга	8,000,000.00	8,000,000.00	00.00	100.0%
210604	Урсгал засвар	2,272,700.00	2,272,700.00	00.00	100.0%
2107	Томилолт, зочны зардал	185,500.00	56,000.00	129,500.00	30.2%
210702	Дотоод албан томилолт	185,500.00	56,000.00	129,500.00	30.2%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	836,900.00	836,900.00	00.00	100.0%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	296,900.00	296,900.00	00.00	100.0%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	540,000.00	00.00	100.0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6525200.00	6143600.00	381,600.00	94.2%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	556,600.00	175,000.00	381,600.00	31.4%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,968,600.00	5,968,600.00	00.00	100.0%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	100000.00	100000.00	00.00	100.0%
2132	Бусад урсгал шилжүүлэг	100,000.00	100,000.00	00.00	100.0%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00	100,000.00	00.00	100.0%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	351,419,900.00	337,894,762.00	13,525,138.00	96.2%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	295,709,100.00	285,293,799.00	10,415,301.00	96.5%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	55,710,800.00	52,600,963.00	3,109,837.00	94.4%
132001	Орон нутгийн төсвөөс	55,710,800.00	52,600,963.00	3,109,837.00	94.4%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	20.00	20.00	00.00	100.0%
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	13.00	13.00	00.00	100.0%

620003	Үйлчлэх ажилтан	06.00	06.00	00.00	100.0%
--------	--------------------	-------	-------	-------	--------

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	778,166.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	778,166.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	778,166.00
2104	Хангамж, бараа материалын зардал	778,166.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	778,166.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	778,166.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	778,166.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	778,166.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Шинэ-идэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хүүхдийн хоолны нормативт зардал, шилэн дансны мэдээлэлтэй холбоотой өгсөн 2 зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Ньюбаланс аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Лхагвадорж, аудиторын туслах Ё.Байгалмаа нар гүйцэтгэж, хяналтыг аудитын чанарын менежер Д.Гэрэлчулуун гүйцэтгэж, хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитор Л.Мандахнаран, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Шинэ-идэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ньюбаланс аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/01 тоот дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Шинэ-идэр сумын Хүүхдийн цэцэрлэг нь хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа оролцоог хангаж, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах зорилго дэвшүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Нийгмийн даатгалын тухай хуульд заасан шимтгэлийн хувь хэмжээнд өөрчлөлт орж, Монгол Улсын засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 2021 оны 43-р тогтоол, “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг шинэчлэх тухай” Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал батлагдаж гарсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шинэ-идэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 385.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 7.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 5.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Шинэ-идэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 21.5 сая төгрөгөөр буюу 0,9 хувиар буурсан байна. Тайлант онд мөнгөн хөрөнгө данс үлдэгдэлгүй байна.

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	0,0	0,0	0,0
Бараа материал	61.1	68.9	7.8
Биет хөрөнгө	2,349.0	2,319.8	-29.2
Биет бус хөрөнгө	7.2	7.1	0.1
Нийт хөрөнгө	2,417.3	2,395.8	-21.5
Дансны өглөг	0,0	0,0	0,0
Засгийн газрын хувь оролцоо	108.6	108.6	
Хуримтлагдсан үр дүн	2,231.1	2,210.7	-20.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	77.6	76.4	1.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,417.3	2,395.8	-21.5

Бараа материалын дансны үлдэгдэл 68.9 сая төгрөг болж, 7.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд бусад хангамжийн материалын дансны үлдэгдэл өсөхөд нөлөөлжээ. Тайлант хугацаанд бараа материалын актлалт бөайхгүй байна.

Биет хөрөнгийн дансны үлдэгдэл 2,319.8 сая төгрөг болж, 29.2 сая төгрөгөөр буурсан нь дахин үнэлж орлого авсан хөрөнгийг данснаас хасахаас гадна ашиглалтын хугацаа нь дуусч дахин ашиглах боломжгүй акталж устгасан үндсэн хөрөнгийг данснаас хассантай холбоотой.

Дансны өглөг данс үлдэгдэлгүй байна.

Засгийн газрын оролцоо данс 108.6 сая төгрөг, хуримтлагдсан үр дүн 2,210.7 сая төгрөг, Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 76.4 сая төгрөг байна.

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 378.9 сая төгрөг, нийт зардал 400.4 сая төгрөг, тайлант үеийн үр дүн -21.5 сая төгрөг байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд дахин үнэлгээтэй хөрөнгө хасагдсантай холбоотой хуримтлагдсан үр дүнд 1.2 сая төгрөгөөр нөлөөлж нийт цэвэр өмчийн дүн 2,395.8 сая төгрөг байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Шинэ-идэр сумын Хүүхдийн цэцэрлэг 2021 оны төсвийн төслийг 421.5 сая төгрөгөөр тооцон төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна. Тайлант онд 376.6 сая төгрөгөөр анх баталж, 25.2 сая төгрөгөөр төсвийн тодотгол хийж, 351.4 сая төгрөгийн төсөв баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Шинэ-идэр сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2021 онд 376.6 сая төгрөг батлагдсанаас 351.4 сая төгрөгийн урсгал санхүүжилт авч, 338.7 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулж 12.7 сая төгрөг хэмнэж орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын дагуу батлагдсан төсвөөс 10 хувийн хэмнэлт гаргах заалтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Боловсролын газраас 0.8 сая төгрөгийг хүлээн авч, Корона вирус-2019 цар тахлаас урьдчилан сэргийлэхэд зориулан ариутгал халдвар хамгаалалын материал авахад зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Дэлхий нийтийг хамарсан Корона вирус-2019 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангах, хөл хорионы үед цэцэрлэгүүд хичээлэхгүй байх, цахим болон зайны сургалт зохион байгуулж, цэцэрлэгт хамрагдах боломжгүй 5 настай хүүхдүүдэд цаасан даалгавар сард 2 удаа хүргэж ажилласан. Цар тахлын улмаас ажиллагсад эрүүл мэндийн асуудал тулгарч ариутгал халдваргүйтгэл, эргүүл постын үйл ажиллагаа эрс нэмэгдсэн.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Шинэ-идэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн гол нөлөө бүхий асуудал нь Засгийн Газраас баримталсан төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг хэрэгжүүлж 12.7 сая төгрөгийн хэмнэлт гаргасан байна. Үүнд: Цалин хөлс болон НДШ-с 5.5 сая төгрөг, тогтмол зардлаас 3.1 сая төгрөг, хоол хүнсний зардлаас 4.1 сая төгрөгийг тус тус хэмнэсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан.

Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийг авч үзэхэд www.shilendans.gov.mn цахим хуудсанд 12 мэдээлэлийг хугацаа хоцроож дутуу мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн зарим хуулийн нийцлийн Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”-ын хэрэгжилтийг хянан үзлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгснийг аудитаар дахин хянахад хэрэгжсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хүүхдийн хоолноос гадна бусад хоол хүнсэнд зарцуулж байгаа зардлыг зарцуулахдаа дээд шатны байгууллагын шийдвэрийн дагуу зарцуулах тал дээр анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1.3 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

4.3 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлээгүй болно

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. *Нормативт зардалтай холбоотой*

1.1 Илрүүлэлт: Цэцэрлэгийн хүүхдийн хоолны гүйцэтгэлийг шалгахад 1 хүүхдэд ноогдох нормативт зардлыг 326 төгрөгөөр хэтрүүлэн зарцуулснаас 1.3 сая төгрөгийн зардал хэтэрсэн байгаа нь хоолны зардлын норматив тогтоох тухай Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 12 сарын 18-ны 450 дугаар тогтоолын 1 дэх заалттай нийцэхгүй Үнэлгээ ба хувиарлалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Хүүхдийн хоолны нормативт зардлыг хэрэгжүүлж ажиллах.

2. *Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой*

2.1. Илрүүлэлт: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийг авч үзэхэд www.shilendans.gov.mn цахим хуудсанд 12 мэдээлэлийг хугацаа хоцроож дутуу мэдээлсэн байна.

Хөвсгөл аймгийн Шинэ-идэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.2. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4."Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ"-д заасан мэдээллийг тухай бүр нэгдсэн системд мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 20 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Шинэ-идэр сумын Хүүхдийн цэцэрлэг	2	1.3							2	1.3

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Э.БАТ-ЭРДЭНЭ

0/25

АУДИТОР

Л.МАНДАХНАРАН

0/25

БЭЛТГЭСЭН:

НЬЮБАЛАНС АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

Б.ЛХАГВАДОРЖ

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР

Д.ГЭРЭЛЧУЛУУН

АУДИТОРЫН ТУСЛАХ

Е.БАЙГАЛМАА